

**ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ
ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН МЭДЭЭ
(2021 оны жилийн эцсийн дүнгийн тухай)**

2021 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Тус газар нь Нийслэлийн Засаг даргын 2013 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/1086 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын дагуу өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг 2021 онд дараах байдлаар зохион байгуулан ажиллалаа.

Нэг. Өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн мэдээ

Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдаас хөдөлмөрийн харилцаатай холбоотой 139, иргэнээс 1 санал, хүсэлт ирснийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын систем (www.egr.uulaanbaatar.mn)-д бүртгэн, холбогдох хууль, журмын дагуу хугацаанд нь шийдвэрлэж ажиллалаа. Тайлант хугацаанд өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явцад зөрчил дутагдал гаргаагүй байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног 21 цаг 59 минут байна.

Иргэнээс ирсэн 1 санал, хүсэлтийг холбогдох газарт нь уламжилж, энэ тухай утсаар танилцуулж ажиллалаа.

Хоёр. Өргөдөл, гомдлын хандалтын мэдээ (өссөн дүнгээр)

Байгууллагад ирсэн өргөдлийг хандалтыг төрлөөр нь ангилбал:

- Ажилд орох, чөлөөлөгдөхтэй холбоотой өргөдөл- 44
- Захиргааны чөлөө хүссэн өргөдөл- 16
- Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай өргөдөл- 34
- Жирэмсний болон хүүхэд асрах чөлөө хүссэн өргөдөл- 23
- Хөдөлмөрийн хөлстэй холбоотой өргөдөл- 20
- Ажилд шилжих, дэвшин ажиллах тухай өргөдөл- 2
- Иргэдээс гаргасан санал, хүсэлт- 1



График 1: Өргөдлийг төрлөөр ангилан харуулав

Гурав. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг өмнөх үеүүдтэй харьцуулсан байдал

Хүснэгт 1

| Д/д | Хугацаа | 2021.01 улирал | 2021.02 улирал | 2021.03 улирал | 2021.04 улирал |
|----------------------------------|---|-------------------------|------------------------|-------------------------|-------------------------|
| Ерөнхий үзүүлэлт | | | | | |
| 1 | Шийдвэрлэлтийн дундаж хугацаа | 2 хоног 18 цаг 30 минут | 6 хоног 7 цаг 26 минут | 4 хоног 15 цаг 59 минут | 4 хоног 21 цаг 59 минут |
| 2 | Хандалтын тоо | 24 | 26 | 36 | 54 |
| 3 | Зөрчлийн үзүүлэлт | 0 | 0 | 0 | 0 |
| Өргөдөл, гомдлын хандалтын төрөл | | | | | |
| 4 | Ажилд орох, чөлөөлөгдөхтэй холбоотой өргөдөл | 10 | 9 | 10 | 15 |
| 5 | Захиргааны чөлөө хүссэн өргөдөл | 5 | 2 | 8 | 1 |
| 6 | Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай өргөдөл | 1 | 10 | 10 | 13 |
| 7 | Жирэмсний болон хүүхэд асрах чөлөө хүссэн өргөдөл | 5 | 5 | 5 | 8 |
| 8 | Хөдөлмөрийн хөлстэй холбоотой өргөдөл | 3 | 0 | 3 | 14 |
| 9 | Ажилд шилжих, дэвшин ажиллах тухай | 1 | 1 | 0 | 0 |
| 10 | Иргэдээс гаргасан санал, хүсэлт | 0 | 0 | 0 | 1 |




График 2. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг өмнөх улиралтай харьцуулсан байдал

Тайлант хугацаанд ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3 дугаар, 4 дүгээр улиралд 4 хоног 04 цаг 21 минут байгаа нь мөн 2 дугаар улирлын дундаж хугацаанаас буурсан боловч 1 дүгээр улирлын шийдвэрлэлтийн дундаж хугацаанаас өссөн дүнгээр харагдаж байна. Энэ нь ажилтны санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцалж буй тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-т хугацааг баримтлан шийдвэрлэж буйтай холбоотой юм.




График 3. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг өмнөх 3 оны мөн үетэй харьцуулсан байдал




График 4. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг өмнөх 3 оны мөн үетэй харьцуулсан байдал

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног 21 цаг 59 минут байгаа нь мөн 2020 оны дундаж хугацаанаас буурсан боловч 2018 оны шийдвэрлэлтийн дундаж хугацаанаас өссөн дүнгээр харагдаж байна. Энэ нь ажилтны санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцалж буй тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-т хугацааг баримтлан шийдвэрлэж буйтай холбоотой юм.

Ажилтан, албан хаагчдаас ирсэн өргөдөл, гомдлыг тухай бүр бүртгэлийн системд байршуулан, шийдвэрлэлтийн явцыг ил тод, шуурхай байлгах зорилгоор явцын тэмдэглэлийг 10 хоног тутамд хөтлөн, 2 удаагийн шат дамжлагатайгаар шийдвэрлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд манай байгууллагад хамааралгүй 14 өргөдөл, гомдлыг холбогдох байгууллагад өдөрт нь шилжүүлж ажиллалаа.

ХЯНАЖ, ТАНИЛЦСАН:

ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН

Т.ИТГЭЛ

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

ХҮНИЙ НӨӨЦИЙН АЖИЛТАН

Н.БУЛГАНЧИМЭГ